

НИЙСЛЭЛ ДҮҮРГИЙН ПРОКУРОРЫН ГАЗРЫН ЯЛ ЭДЛҮҮЛЭХ
АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ХАРИУЦСАН ПРОКУРОРЫН БОЛОН
НИЙСЛЭЛИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЛБАНЫ
ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭГЧ НАРЫН
ХАМТАРСАН ЗӨВЛӨГӨӨН

1. Зөвлөгөөний зорилго:

Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны чанарыг сайжруулах ялын биелэлтийг нэмэгдүүлэх, тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэх, цаашид авах арга хэмжээг тодорхойлоход хамтарсан зөвлөгөөний зорилго оршино.

2. Зөвлөгөөн хамрагдах бүрэлдэхүүн: Нийслэл болон дүүргийн прокурорын ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих, НШГАлба, Найлах дүүрэг, Багануур дүүргийн шийдвэр гүйцэтгэх албаны шийдвэр гүйцэтгэгч нар оролцлоо.

3. Зөвлөгөөн явагдах газар, хугацаа: Нийслэлийн прокурорын газрын хурлын зааланд 2014 оны 04-р сарын 22-ны өдрийн 13 цагт явагдсан.

4. Зохион байгуулагч: Нийслэлийн прокурорын газрын ял эдлүүлэх ажиллагаанд тавих хяналт тавих газар, Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх алба,

Зөвлөгөөнийг нээж :Нийслэлийн прокурорын туслах, Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт хариуцсан хэлтэсийн дарга, Отгонбаяр –Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны чанарыг сайжруулах, ялын биелэлтийг нэмэгдүүлэх, тулгамдаж буй асуудалын талаар харилцан ярилцсан.

Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны дарга, хурандаа Э.Батбаяр
Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хариуцсан шинээр томилогдсон бүтэц бүрэлдэхүүнийг танилцуулаж, Хорихоос өөр төрлийн ялийн биелэлтийг ахиулж цаашид дүүргийн прокурортой хамтарч, үр бүтээл гаргаж ажиллах, мөн Монгол Улсын Хууль зүйн А/130, 131 шинэчлэгдэн батлагдсан журмыг мөрдлөгө болгон ажиллах талаар ярилцсан.

Илтгэгч: Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих ахлах мэргэжилтэн дэслэгч, Р.Цэнд-Аюуш Торгуулийн ял, эд хөрөнгө хураах ялд биелэгдэх боломжгүй талаар хүндрэл гарч байгаа талаар мэдэгдэл хийсэн. Хурал 15 цаг 30 минутанд дуусав.

НИЙСЛЭЛИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЛБА